



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 8/371

Арвайхээр

### Тарваган тахал өвчинөөс сэргийлэх хянах ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын ‘Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай’ хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт болон Эрүүл мэндийн сайдын 2020 оны Тарваган тахал өвчинөөс сэргийлэх, хянах ажлыг эрчимжүүлэх 24 дүгээр Албан даалгаварыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тарваган тахал өвчинөөс сэргийлэх, хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, аймгийн хэмжээнд зохион байгуулагдах тарваган тахал өвчинөөс урьдчилан сэргийлэх, хянах, ажлыг эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Захирамжийг хэрэгжүүлэхэд оролцох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтныг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар (Д.Шивааннурдэв), Зоонозын өвчин судлалын төв (Б.Сүхбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал)-т даалгасугай.



ОРЛОГЧ

И.ДОРЖСҮРЭН

011100847

Аймгийн Засаг даргын 2020 оны 08  
дугаар сарын 17-ны өдрийн 13.1 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

ТАРВАГАН ТАХАЛ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,  
ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Сүхбаатар –аймгийн Засаг даргын дэргэдэх Зоонозын  
өвчин судлалын төвийн дарга  
Гишүүд: Б.Сайнжаргал -Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн  
дарга  
М.Золзаяа - аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын  
Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга  
Н.Нямхайнямбуу –Аймгийн Онцгой байдлын газрын Гамшигаас хамгаалах  
төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн,  
гамшигаас хамгаалах улсын хяналтын байцаагч, хошууч  
Д.Лхагважав - аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын  
газрын Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын  
хэлтсийн дарга  
Б.Бүрэнтөгс –аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн  
дарга, хошууч  
С.Хоролмаа - аймгийн Засаг даргын дэргэдэх Зоонозын өвчин судлалын  
төвийн их эмч  
Ж.Дэмиддолгор –Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Халдвартын  
тасгийн эрхлэгч, их эмч  
Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар  
Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч, сум, өрхийн Эрүүл  
мэндийн төвийн дарга нар  
Нарийн бичгийн дарга: С.Сосорбурам -аймгийн Засаг даргын дэргэдэх Зоонозын  
өвчин судлалын төвийн лабораторийн тасгийн эрхлэгч  
их эмч

-оОо-

Аймгийн Засаг даргын 2020 оны 08  
дугаар сарын 21-ны өдрийн 12 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

**АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ТАРВАГАН ТАХАЛ ӨВЧНӨӨС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ, АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2020.08.19

Арвайхээр

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэх албан байгууллага	Хамтран ажиллах албан байгууллага	Хүрэх үр дүн
Нэг. Удирдлагын зохион байгуулалт					
1.1	Тарваган тахал өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, салбар хоорондын мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж орон нутгийн онцлогт тохирсон эрсдлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан гамшигаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх	YIII/21	ЗДТГ	ОБГ, ЭМГ, ЗЭСТ	Төлөвлөгөө хэрэгжилт 90 хувиас дээш
1.2	Тарваган тахлын байгалийн голомтын халдварын зэрэглэлд үндэслэн эрсдэлийг бууруулах арга хэмжээ (мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэл)-г удирдан зохион байгуулж дэмжлэг үзүүлэх	YIII/21-IX/15	ЗДТГ	Сумдын ЗДТГ	Эрсдэлийг бууруулах арга хэмжээ зохион байгуулгасан байна.
1.3	Тарваган тахал өвчний голомтод ажиллах салбар хоорондын мэргэжлийн багийг томилгоожуулж сургалтанд хамруулах, дадлагажуулах	YIII/24-IX/05	ОБГ	ЗДТГ, ЭМГ, МХГ, ЦГ, ЗЭСТ	Мэргэжлийн багийг томилж сургалтанд хамруулсан байна.
1.4	Тарваган тахлын байгалийн голомтын тандалт судалгаа, дархлаажуулалт, урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагад тусламж үзүүлэх	IX/26-X/15	ЗЭСТ	ОБГ, ЭМГ, сумдын ЭМТ, ӨЭМТ	Холбогдох эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлсэн байна.
1.5	Аймгийн засаг даргын А/315 дугаартай захирамжийн хүрээнд тарваган тахлын голомтод нутагт (Тарагт, Уянга, Нарийнтээл, Хайрхандулаан, Зүүнбаян-Улаан) эргүүл шалгалт хийх	YIII/26-X/15	ОБГ, ЦГ, МХГ, ЗЭСТ	Сумдын ЗДТГ, ЦХ	Хуваарь гаргаж эргүүл шалгалт хийгдсэн байна.

1.6	Цахим орчноор дамжуулан хууль бусаар агнасан тарвага худалдаалах, олон нийтийг уриалсан шинжтэй мэдээ, мэдээлэлд хяналт тавьж таслан зогсоох	YIII/26-X/15	ТГ	ЦГ, МХГ	Тогтмол шалгах, хариуцлага тооцох
1.7	Тарваган тахлын өндөр эрсдэлтэй сумдад анхааруулах самбар байршуулах, “экологийн цагдаа”-г дайчлан ажиллуулах сургалтанд хамруулах	YIII/20-X/15	ЗДТГ	ЦГ, Сумдын ЗДТГ, ЦХ,	Анхааруулах самбар байршуулж экологийн цагдааг тогтмол ажиллуулах
1.8	Тарвага агнасан иргэдэд хүлээлгэх хуулийн хариуцлага тооцоход хууль хяналт, мэргэжлийн байгууллагыг татан оролцуулах, үүрэгжүүлэх	YIII/20-X/15	МХГ	ОБГ, ЦГ	Хуулийн дагуу арга хэмжээ авах
1.9	Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчооны хяналтыг сайжруулах	YIII/26-X/15	ОБГ, ЦГ, МХГ	АТГ, сумдын ЗДТГ	Хууль бус ан агнуурыг тээвэрлэх, худалдаалах үйл ажиллагааг таслан зогсоох

**Хоёр. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр**

2.1	Тарваган тахлын хариу арга хэмжээний бэлэн байдлын нөөцийг (хамгаалах хувцас хэрэгсэл, халдвартгуйжүүлэлтийн бодис, эм эмнэлэгийн хэрэгсэл, шатахуун) үнэлж, нөхөн хангалт хийх	YIII/21-IX/04	ЭМГ, ЗӨСТ	БОЭТ, ӨЭМТ, Сумдын ЭМТ,	Нөөц бэлэн байдал хангагдсан байна.
2.2	“Тарваган тахал өвчинөөс урьдчилан сэргийлэх, сэжигтэй болон батлагдсан тохиолдолд халдварт хамгаалалын дэглэм баримтлах” сэдэвт сургалт /БОЭТ, ӨЭМТ-үүдэд танхимаар, сумдын ЭМТ-үүдэд цахимаар/ зохион байгуулах.	YIII/24-YIII/29	ЭМГ, ЗӨСТ	БОЭТ, ӨЭМТ, Сумдын ЭМТ,	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, хандлага сайжирсан байна.
2.3	“Тарваган тахлын сэжигтэй болон батлагдсан тохиолдолд хувийн хамгаалах хэрэгсэл өмсөж тайлах дараалал” сэдэвт сургалт /БОЭТ, ӨЭМТ-үүдэд танхимаар, сумдын ЭМТ-үүдэд цахимаар/ зохион байгуулах.	YIII/24-YIII/29	ЭМГ, ЗӨСТ	БОЭТ, ӨЭМТ, Сумдын ЭМТ,	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, хандлага сайжирсан байна.
2.4	“Хууль бус ан, агнуураас сэргийлэх, холбогдох хууль эрх зүй” сэдэвт сургалтыг /БОЭТ, ӨЭМТ-үүдэд танхимаар, сумдын ЭМТ-үүдэд цахимаар/ зохион байгуулах.	YIII/24-YIII/29	ЭМГ, ЗӨСТ	БОЭТ, ӨЭМТ, Сумдын ЭМТ,	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, хандлага сайжирсан байна.
2.5	Өндөр халуурах, ханиалгах, амьсгаадах булчирхай цочих, суулгах зэрэг шинж тэмдэгтэй өвчтнөөс тархвар судлалын асуумж судалгааг заавал тодруулж авч хэвшүүлэх (ЭМС-ын 2017	тогтмол	БОЭТ, ӨЭМТ, Сумдын ЭМТ	ЭМГ, ЗӨСТ	Сэжигтэй тохиолдол бүрт тархвар судлалын асуумж авч хэвшсэн байна.

	оны А/160 тоот тушаал “Тарваган тахал өвчний хяналт сэргийлэлтийн заавар”-ын дагуу)				
2.6	Сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед ЭМГ, ЗӨСТ яаралтай мэдээлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах	тогтмол	БОЭТ, ӨЭМТ, Сумдын ЭМТ	ЭМГ, ЗӨСТ	Яаралтай мэдээлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах
Гурав. Эмнэлэгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр					
3.1	Зоонозын халдварт өвчний сэжиг илэрсэн, өвчлөл бүртгэгдсэн тохиолдолд мэргэжлийн яаралтай тусламж үзүүлэх багийг томилгоожуулах	ҮIII/30	ЭМГ	ЗӨСТ	1, 2 дугаар баг томилогдсон байна.
3.2	БОЭТ, Сумдын ЭМТ-үүд Эрүүл Мэндийн Сайдын 2019 оны А/537 дугаар тушаалын 9 дүгээр хавсралт “Тусгаарлан сэргийлэлтийн заавар”-ын 1.7 заасны дагуу тусгаарлах өрөөг бэлтгэх	ҮIII/21- ҮIII/28	БОЭТ, Сумдын ЭМТ	ЭМГ, ЗӨСТ	Тусгаарлах өрөөг зааврын дагуу бэлэн байлагах
3.3	Тарваган тахлын сэжигтэй тохиолдлын шалгуур үзүүлэлтэд тохирсон өвчтнийг анх оношилсон эмч, эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгчийг тусгаарлах өрөөнд тусгаарлаж яаралтай мэдээллэх	Тохиолдол бүртгэгдсэн үед	БОЭТ, Сумдын ЭМТ	ЭМГ, ЗӨСТ	Тарваган тахлын сэжигтэй тохиолдолыг тусгаарлаж схемийн дагуу мэдээллэх
3.4	Өвчний сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед халдварын сэргийлэлт хяналтыг чанд мөрдөх	Тохиолдол бүртгэгдсэн үед	БОЭТ, ӨЭМТ, Сумдын ЭМТ	ЭМГ, ЗӨСТ	Халдварын сэргийлэлт хяналтыг чанд мөрдөх
3.5	Эмнэлэг дотор халдвар гарсан тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээг холбогдох журам, зааврын дагуу төлөвлөх, зохион байгуулах, хүний нөөцийн бэлэн байдлыг хангах.	Тохиолдол бүртгэгдсэн үед	БОЭТ, ӨЭМТ, Сумдын ЭМТ	ЭМГ, ЗӨСТ	Тохиолдол бүртгэгдсэн үед бэлэн байдал хангах
3.6	Тарваган тахал өвчний сэжигтэй болон батлагдсан тохиолдол бүртгэгдсэн үед тархвар судлалын тандал судалгаа, лабораторийн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ хийх мэргэжлийн багийг тухай бүр томилгоожуулж, тохиолдолын удирдлагын тогтолцоонд шилжин ажиллах, мэргэжил арга зүйн удирдамжаар хангах	Тохиолдол бүртгэгдсэн үед	ЭМГ, ЗӨСТ	ОБГ, МХГ, БОЭТ, ӨЭМТ, Сумдын ЭМТ	Голомтыг таслан зогсоох
3.7	Тарваган тахлын голомтот сумдад дархлаажуулалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулж, мэдээг нэгтгэн ЗӨСҮТ хүргүүлэх	ҮIII/24	ЗӨСТ	Сумдын ЭМТөвүүд, ӨЭМТ	Дархлаажуулалтын хувь
3.8	Хяналт шалгалт, эргүүл, постоор хураагдсан тарваганы арьс, махыг лабораторийн шинжилгээнд хамруулж, дүгнэлт гаргаж, устгал хийх өгөх	ҮIII/25-Х/15	ЗӨСТ	МХГ, ЦГ, ОБГ, ТГ Сумдын БОХ-ын байцаагч,	Шинжилгээнд хамрагдсан болон устгал хийгдсэн тоо

				Цагдаагийн тасаг	
<b>Дөрөв. Ард иргэдэд тарваган тахал өвчинөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах</b>					
4.1	Мэдээлэл сурталчилгааны цуврал зөвлөмж, сэрэмжлүүлгийг олшруулан хүн ам олноор цугладаг үйлчилгээний газруудад тогтмол түгээх	YIII/25-X/15	ОБГ, МХГ, ЭМГ, ЗӨСТ	Сумдын ЭМТөвүүд	Зөвлөмжийн тоо Байршуулсан байгууллагын тоо
4.2	Тарваган тахал өвчинөөс урьдчилан сэргийлэх богино хэмжээний видео, хэвлэлийн бага хурал, цаг үеийн мэдээ мэдээлэл зэргийг бэлтгэж орон нутгийн телевизүүдээр нэвтрүүлэх	YIII/25-X/15	ОБГ, МХГ, ЦГ, ЗӨСТ, БОЭТ, ЭМГ ӨЭМТ, Сумдын ЭМТөвүүд	Орон нутгийн телевиз	Мэдээллийн тоо
4.3	ЭМЯ, ЗӨСҮТ-өөс гарч байгаа зөвлөмж сэрэмжүүлэгийг өдөр бүр мэргэжлийн байгууллагуудын фэйж хуудас болон олон нийтийн сүлжээнд байршуулсан сурталчилах	YIII/25-X/15	ЭМГ, ОБГ, МХГ, ЦГ, ЗӨСТ, БОЭТ, ӨЭМТ, Сумдын ЭМТөвүүд	ОБГ, МХГ, ЦГ, ЗӨСТ, БОЭТ, ӨЭМТ, Сумдын ЭМТөвүүд	Зөвлөмж, сэрэмжлүүлгийн төрөл, тоо

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:  
 ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН  
 ЛАБОРАТОРИЙН ИХ ЭМЧ:  С.ХОРОЛМАА  
 ШИМЭГЧ СУДЛАГЧ:  Б.ГАНБАТ

ЗӨСТ-ИЙН ДАРГА:  Б.СУХБААТАР  
 ХЯНАСАН: